



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/125

Хажуу шинэ үс

**Сумын Засаг даргын дэргэдэх зөвлөл
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66.1, 59.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг боловсруулах, санал оруулах, биелэлтэнд хяналт тавих, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилго бүхий Засаг даргын дэргэдэх зөвлөлийг хавсралтанд заасан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

2.Сумын Засаг даргын дэргэдэх зөвлөлийн ажиллах журмыг хууль тогтоомжийн хүрээнд боловсруулан хэлэлцүүлж, мөрдүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох)-д даалгасугай.

3.Сум орон нутгийг хөгжүүлэх, төсөл хөтөлбөр боловсруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, дүрэм журмыг мөрдөж идэвхи санаачлагатай ажиллах хүлээсэн үүргээ үр дүнтэй биелүүлэхийг Сумын Засаг даргын дэргэдэх зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ДОРЖСҮМБЭР

482401125

Засаг даргын 2024 оны 12
сарын 13-ний өдрийн А/126
тоот захирамжийн хавсралт

ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:	Б.Доржсүмбэр	(Засаг дарга)
Нарийн бичгийн дарга:	Н.Өлзийтогтох	(Засаг даргын Тамгын газрын дарга)
Гишүүдэд:	Н.Ганбат	(Санхүү албаны дарга)
	А.Мөнх-Уянга	(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
	Д.Сарангэрэл	(Хөдөө аж ахуй мэргэжилтэн)
	Н.Долгорсүрэн	(Эрүүл мэндийн төвийн дарга)
	Д.Дагмидмаа	(Ахмадын холбооны дарга)
	Б.Мөнхдэлгэр	(1 дүгээр багийн Засаг дарга)
	М.Амарзаяа	(2 дугаар багийн Засаг дарга)
	Н.Энхтайван	(3 дугаар багийн Засаг дарга)
	Г.Нандин-Эрдэнэ	(Малчдын төлөөлөл)
	А.Ууганбаяр	(Аж ахуй нэгжийн төлөөлөл)
	Д.Алтансаргай	(Татварын байцаагч)